



**ҮНДЭСНИЙ  
ХУВЬЧЛАЛЫН  
САН**

**2024**

**ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН**

## **ЭРХЭМ ХҮНДЭТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНАА**

Монголын хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Сан нь Монгол улсын төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож өгөөж ашгаа хөрөнгө оруулагчдадаа өгөх эрхэм зорилгынхоо хүрээнд бидний эргэн тойронд юу болж байгаа үйл явдал, хөрөнгө оруулалтаа бодлого стратегиа хэрхэн хэрэгжүүлсэн талаар энэхүү тайлангаар харуулахыг зорилоо.

Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого болох төрийн өмчит компаниудын хувьчлалд оролцож бодит өгөөжийг хөрөнгө оруулагч нартаа хүртээх эрхэм зорилгынхоо хүрээнд “Монголын Хөрөнгийн Бирж ХК” /MSE:MSE/-д хөрөнгө оруулалт хийж эхэлсэн билээ.

“Монголын Хөрөнгийн Бирж ХК” нь 2022 оны 12-р сард олон нийтэд нэгж хувьцааны үнийг 100 төгрөгөөр санал болгож байсан бол хэдийнээ 450 төгрөг хүрээд байна.

Зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан бидний эзэмшиж буй зарим нэг хувьцаа уналттай хаагдсан хэдий ч компанийн үнэ цэнэ болон үнийн хооронд ихээхэн ялгаа байдаг билээ. Зах зээлийн нөхцөл байдал эргэх үед томоохон өөрчлөлтүүд гарна гэж бид үзэж байна.

Сангийн менежер

Ч.Даваасамбуу

## ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:ХОС) нь 2020 оны 10 дугаар сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 3 жил хагасын хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд цар тахал, томоохон геополитикийн асуудлууд үүсэж улс орнуудын эдийн засаг, хөрөнгийн зах зээлийг ихээхэн уналтад оруулсан хэдий ч манай хамт олон тухай бүрт хөрөнгө оруулалтын зохистой шийдвэр гаргаж чадсанаар сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮5 тэрбумаас ₮5.9 тэрбумд хүрч чамлахааргүй өсөлтийг үзүүлж чадсан байна. Иймээс 2024 оны сүүлийн хагас жилийг хөрөнгийн зах зээлийн сэргэлтийг бататгах хугацаа хэмээн бид таамаглаж байна. 2024 эхний хагасын байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ ₮120.60 хүрч оны эхнээс 4.4% буурсан байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 15.3%-иар өсөөд байна.
- ХОС нь 2021 онд багцынхаа дийлэнх хувийг урт хугацаанд өндөр өгөөж өгөх компаниудыг сонгон хөрөнгө оруулалтууд хийсэн. Сан нь хамгийн сайн үзүүлэлттэй урт хугацаанд үнэ цэнээ хадгална гэж тооцоолсон компаниудаар өөрийн хувьцааны багцаа бүрдүүлсэн ба бид мөн 2024 эхний хагасын байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Монголын Хөрөнгийн Бирж ХК(MSE:MSE) хувьцааг Growth at a reasonable price (GARP) буюу өсөлттэй хувьцааг боломжийн үнээр худалдан авах хөрөнгө оруулалтын стратеги ашиглан бага ханшаар худалдан авч тухайн хувьцаан дээр өндөр өсөлтийг үзүүлсэн билээ.

Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2020	2021	2022	2023	2024Q2
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж	25.6%	91.2%	-24.4%	-10.63%	-4.4%
ТОП-20-ийн өгөөж	-1.7%	130%	-15.4%	10.31%	8.89%
Хадгаламжийн хүү	11.3%	~9%	10.3%	12.00%	10.15%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

## ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр  
**ХОС**

Гаргасан нэгж эрх  
**50 сая ширхэг**

Нэгж эрх эзэмшигчийн тоо  
**6,305**

Нэгж эрхийн хаалтын ханш  
**₮100.97**

Зах зээлийн үнэлгээ  
**₮5.05 тэрбум**

Жилийн арилжааны эргэлт  
**₮229.5 сая**

Нэгж эрхийн NAV  
**₮120.68**

Нийт цэвэр хөрөнгө NAV  
**₮5.96 тэрбум**

## ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн дарга**

**Мэргэжил:** Эдийн засагч, санхүүч

**Албан тушаал:** “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн  
гишүүн, Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК”  
ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Батбилэгийн Золбоо

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Мэргэжил:** Санхүү, эдийн засаг

**Албан тушаал:** “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн  
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, “Ард  
Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга



Чулуунбаатарын Хандаа

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Мэргэжил:** Эдийн засагч

**Албан тушаал:** “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн ТУЗ-  
ийн хараат бус гишүүн**

**Мэргэжил:** Бизнесийн удирдлага

**Албан тушаал:** ХҮИС-ийн НББ, Санхүүгийн тэнхим  
ахлах багш



**Батхүүгийн Ариунболд**

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Мэргэжил:** Санхүүгийн удирдлага

**Албан тушаал** Интергрупп Интернэйшнл ХХК,  
Санхүү эрхэлсэн захирал

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



**Чадраабал Даваасамбуу**

**Мэргэжил:** Санхүү, Хөрөнгө оруулалт

**Албан тушаал:** “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн  
сангийн менежер

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэчилсэн журмын дагуу Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг билээ.


## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2023 оны эцсийн байдлаар Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,163 байсан бол оны 2024 оны эхний хагасын байдлаар 6,305-д хүрч 2.3%-иар өссөн байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо өмнөх жилийнхтэй ойролцоо түвшинд байгааг харвал сангийн үйл ажиллагаа хэвийн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ буураагүй байгаа зэргийг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ ХК	5,658,294	11.3%
ТУЛГА	3,000,000	6.0%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК	2,500,000	5.0%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ	2,500,000	5.0%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС	2,234,898	4.5%
АРД КРЕДИТ ББСБ	1,558,998	3.1%
БОГД БАНК	1,371,500	2.7%
МАНДАХБАЯР	1,000,000	2.0%
НАРАНБАТ	1,000,000	2.0%
ЦЭРЭНДОЛГОР	807,141	1.6%
Бусад 6,295	28,369,169	56.8%
<b>Нийт</b>	<b>50,000,000</b>	<b>100.00%</b>

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


ХОС нь 2024 оны эхний хагас жилд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд түлхүү хөрөнгө оруулалт хийж ажиллаа. Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2024 оны эхний хагасд 6.03 тэрбум төгрөгт хүрч 4.4%-иар, зах зээлийн үнэлгээ нь 5.05 тэрбум төгрөгт хүрч 5.4%-иар тус тус буурчээ. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 21%-иар өсөөд байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
06/27/2024	100.97	120.68
Оны эхнээс %	-5.40%	-4.42%
Сан нээгдсэнээс хойш	0.97%	20.68%
2024 оны доод дээд	90.92-102.93	112.99-125.92


## Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК



## Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

ХОС-ын хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй компанийн хувьцаад түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба багцын дийлэнх буюу 75 хувийг дангаар бүрдүүлж байна. Тайлант хугацаанд гадаад дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан дотоод болон гадаадын тодорхой хувьцаануудаа зарж гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой хувьцаануудаар багцаа сэлгэн хөрөнгө оруулалтууд хийсэн. Мөн тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл багцдаа нэмж багцын 15 орчим хувьд хүргэсэн.

2024 оны 06 дугаар сарын 30-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 31 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 25 нь дотоодын хувьцаа, 6 нь гадаад хувьцаа байна. Салбараар нь харвал санхүүгийн 13, өргөн хэрэглээний 4, түүхий эдийн 4, аж үйлдвэрийн 4, тогтмол бус хэрэглээний 4, технологийн 3, харилцаа холбооны салбарын 1 хувьцаануудаас багц бүрджээ.

**Хувьцааны багц, эдийн засгийн салбараар** (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

## САНГИЙН ЗАРДАЛ

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 5,865 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 138.1 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн дундаж үлдэгдлээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2024 оны эхний хагаст 2.35% байна.

### Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

## САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 82%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.


### Өдрийн NAV хөдөлгөөний тархалт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

## НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог. ХОС-ын нэгж эрхийн арилжааны эргэлт 2024 онд ₮229.5 сая байгаа ба нийт 2.37 сая ширхэг нэгж эрх арилжаалагдсан ба энэ нь сангийн 4.74 хувь гар сэлгэсэн байна.



## САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сан болон Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн Ч. Даваасамбуу нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаа. Үндэсний Хувьчлалын Сангийн хувьд хөрөнгө оруулалтын багцыг удирдах, сангийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Нийт 637.2 сая төгрөгийн нийт 485 хэлцэл хийгдсэн ба 10 хувьцаагаар дамжуулан хийлээ.

Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.

Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтууд хийдэг ба хэтэрхий өндөр үнэлэгдсэн тодорхой хэдэн хувьцаануудаас гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой дунд хугацааны хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банкинд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 6,054 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 5,989 сая төгрөгт хүсэн бөгөөд 2023 оны мөн үетэй харьцуулахад хөрөнгө 8.2%, цэвэр хөрөнгийн дүн 6.5%-ийн бууралтыг тус тус үзүүлсэн байна.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2023 Q4	2024 Q2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,402</b>	<b>6,054</b>
Мөнгө	725	589
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	5,657	5,443
Авлага	7	9
Хойшлогдсон татварын хөрөнгө	13	13
<b>Нийт өр төлбөр</b>	<b>26</b>	<b>64</b>
Дансны өглөг	14	52
Орлогын татварын өр	12	12
Хойшлогдсон татварын өр		
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>6,375</b>	<b>5,989</b>
Өмч	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг	1,375	989

### ОРЛОГЫН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2023 Q4	2024 Q2
Хүүгийн орлого	19	5
Ногдол ашгийн орлого	174	158
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	(728)	(412)
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(535)</b>	<b>(249)</b>
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(155)	(68)
Кастодианы үйлчилгээний зардал	(22)	(12)
Бусад зардал	(59)	(57)
<b>Нийт үйл ажиллагааны зардал</b>	<b>(236)</b>	<b>(137)</b>
Татварын өмнөх ашиг	(771)	(387)
Хойшлогдсон татварын зардал	(22)	0
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	<b>(793)</b>	<b>(387)</b>

## 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Сүүлийн он жилүүдэд дэлхий дахин эдийн засаг санхүүгийн хувьд тааварлахын аргагүй зүйлүүдтэй учирсан. Олон улсын валютын сангаас гаргасан судалгаанаас харахад 2024 онд Дэлхийн ДНБ-ийн жилийн өсөлт 3.2 хувь гарч өмнөх тайлант үетэй адил байх таамаг гарлаа. Инфляцын хувьд 5.8 хувьд хүрч 2023 оныхтой харьцуулахад 0.9 хувиар саарах таамаг гаргасан байна. 2024 оны Дэлхийн ДНБ 2023 онтой ижил хэмжээд буюу өсөхгүй байх боломжтой бөгөөд уг шалтгааныг тодорхойлбол олон улсын хэмжээнд тэр дундаа БНХАУ-д эдийн засгийн өсөлт хүлээлтээс удааширвал мөн геополитикийн хурцадмал байдал даамжирвал улс орнуудын импорт, экспорт мөн ачаа тээврийн хүндхэн нөхцөл байдал үүсэх боломжтой байгааг онцоллоо.

Монгол улсын эдийн засаг 2023 онд 7.0 хувийн өсөлттэй гарсан. Харин инфляцын түвшин 2024 оны 5-р сарын байдлаар 5.7 хувьд хүрэв. 2024 онд уул уурхайн салбар тэлж хувийн хэвшлийн үйл ажиллагаа хэвийн түвшиндээ очиж төсөв томорсноор эдийн засгийн өсөлт 4.8 хувьд хүрэх боломжтой байна.


ДНБ болон инфляцын жилийн өсөлтийн харьцуулалт(2023, 2024У1 он)

Эдийн засгийн үзүүлэлт	Улс	2023	2024У1	Зөрүү
ДНБ өсөлт	Монгол	7.0%	7.8%	10.26%
	АНУ	1.6%	1.3%	-23.08%
	БНХАУ	4.5%	5.30%	15.09%
	ЕХ	1%	0.30%	-233.33%
	Дэлхий	2.90%	1.60%	-81.25%
Инфляцын өсөлт	Монгол	7.90%	7.0%	-12.86%
	АНУ	3.40%	3.50%	2.86%
	БНХАУ	0.20%	0.30%	33.33%
	ЕХ	3.40%	2.7%	-25.93%
	Дэлхий	6.90%	7.50%	8.00%

Эх сурвалж: ОУВС

Ковид-19 цар тахал, ОХУ болон Украин улсын дайн мөн бусад геополитикийн асуудлаас үүдэн хөрөнгийн зах зээл маш том уналтыг сүүлийн жилүүдэд үзүүлсэн тэгвэл 2023 онд дэлхийн хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд ихэнх нь өсөлттэй гарч байсан саяхан бол 2024 оны эхний улиралд тус өсөлтөө илүү бататгалаа. Жишээлбэл бидний сайн мэдэх АНУ-ын ТОП500 компанийн индекс болох S&P 500 бүх цагийн дээд ханшаа тогтоосон юм.


### Голлох хөрөнгийн захын индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмбэрг

Худалдаа болон геополитикийн хурцадмал байдал нь дэлхийн эдийн засгийн удаашралд сэргээр нөлөөлж, 2023 онд дэлхийн ГШХО-ын урсгал хоёр хувиар буурч, 1.3 их наяд ам.доллар болжээ энэ нь 2022 онтой харьцуулахад 10%-иар бага үзүүлэлт юм.

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт




Эх сурвалж: НҮБ



Азийн хөгжлийн банкны гаргасан Монгол улсын эдийн засгийн судалгаанаас харахад 2023 онд Монгол улс ашигт малтмалын олборлолт, экспортын хэмжээ, төлбөрийн тэнцэл, төсвийн ашиг, нэмэгдсэнээр Монгол Улсын эдийн засаг 2023 онд тогтвортой өсөлттэй буюу 7%-д хүрснийг дурдсан байна. 2024 оны хувьд өсөлтийг 4.1% хэмээн тооцоолсон учир нь 2024 оны өвөл болсон зуд Монгол улсын хөдөө аж ахуйн салбарыг хүндхэн нөхцөл байдалд оруулсан гэж харж байгаа аж.


### Азийн хөгжлийн банкнаас гаргасан Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Азийн Хөгжлийн банк

Монгол улсын гадаад валютын нөөц 2024 оны 5-р сарын байдлаар 5,183 сая ам.доллар буюу түүхэн дээд хэмжээнд хүрээд байгаа юм. Тус өсөлтөд арилжааны банкаар дамжин ирэх валютын урсгал сайжирсан, гадаад худалдааны тэнцэл эерэг гарсан зэрэг хүчин зүйлс чухал нөлөө үзүүлсэн. Ингэснээр Монгол улсын зээлжих зэрэглэлд эергээр нөлөөлөх замаар хувийн хэвшлийн санхүүгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэдий ч төгрөгийн ханш чангарснаар Монгол улсын экспортын барааны үнэ нэмэгдэж, импортын барааны үнэ багасах нь дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварт нөлөөлөх нь бий.

### Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголын Банк